



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар сарын 21-ний  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 511

#### АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН СОЛБИЦЛЫН ТУХАЙ

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.3, 9.1.11-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг 1 дүгээр хавсралт ёсоор тогтоосугай.
2. Засгийн газрын 2014 оны 239 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайгаас энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан солбицол бүхий талбайг хассугай.
3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тухай бүр нийтэд мэдээлэн ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ул уурхайн сайд РЖИГЖИД, Ашигт малтмалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяа нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Уул уурхайн сайд

РЖИГЖИД